

Хувьцаа эзэмшигчдийн 2023 оны 04 сарын 21-ны
өдрийн хурлаар хэлэлцүүлэв.

**“Тээвэр Дархан” ХК-ний 2022 оны
Санхүүгийн ажлын тайлан**

Компанийн 2022 оны бизнесийн үйл ажиллагааны эдийн засаг, санхүүгийн үр дүнгийн талаар танилцуулъя.

Хөрөнгө

2022 оны жилийн эцсийн тайлангийн үндсэн үзүүлэлт болох нийт хөрөнгийн дүн 3617,9 сая төгрөг байна. Үүнээс эргэлтийн хөрөнгө 416,8 сая төгрөг буюу 11,5%-ийг, эргэлтийн бус хөрөнгө 3201,1 сая төгрөг буюу 88,5 %-ийг эзэлж байна. Санхүүгийн эх үүсвэрт нийт өр төлбөр 668,5 сая төгрөг, эзэмшигчийн өмч хөрөнгө 2949,4 сая төгрөг байна. Үүнээс тухайн жилийн ашиг 169,3 сая төгрөг байна. Тухайн үзүүлэлтүүдийг нийт хөрөнгийн дүнтэй харьцуулахад өр төлбөр 18,5 %, хуримтлагдсан ашиг 30,1% байна.

Орлого

Тайлангийн жилд компанийн үйл ажиллагааны мөнгөн эх үүсвэр нь Шинэ зах, Буян зах, Дархан зах худалдааны төвийн түрээсийн орлогууд болон дэлгүүрийн борлуулалтын орлогоос бүрдэж байна.

Орлогын бүтэц.

д/д	Үзүүлэлт	1-р улирал	2-р улирал	3-р улирал	4-р улирал	Дүн /сая/	
						Төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Борлуулалтын орлого	808,5	767,4	916,3	926,0	3500,0	3418,2

2021 оны нийт борлуулалтын орлого 2073,9 сая төгрөг байсан ба 2022 оны нийт борлуулалтын орлого 3418,2 сая төгрөг байна. Үүнээс харахад 2021 оны борлуулалтын орлого өмнөх жилээс 1344,3 сая төгрөгөөр өссөн үзүүлэлтэй харагдаж байна. 2022 оны борлуулалтын орлого өссөн нь манай оронд төдийгүй дэлхий даяаар тархсан ковид-19 болох цар тахалын улмаас нийт түрээслэгчдийн борлуулалтын орлого буурч санхүүгийн байдал хүндэрсэн нь мөн манай компаний хувьд ч ялгаагүй түрээслэгчдийн тоо буурах хандлагатай байсан учраас компаний зүгээс захирлын зөвлөлийн хурлаар шийдвэр гаргаж нийт түрээсийн төлбөрийг 2021 оны 1-р сараас 8 сар хүртэл 30%, 9-р сараас 12-р сарыг дуустал тус тус 15%-р хөнгөлсөн болно.

2022 оны борлуулалтын орлого өссөн харагдаж байгаа хэдий ч нийт үйлчлүүлэгчдийн худалдан авах чавдар муу байгаатай мөн түрээслэгчид солонгос улсруу ажил хийхээр явж байгаатай холбоотойгоор түрээсийн орлого буурах хандлагатай бна.

Манай компани хувьд ашиглалтын зардал, урсгал засварын зардал өсөж санхүүгийн хувьд хүндрэлтэй байгаа хэдий ч одоогоор түрээсийн төлбөрийг тогтвортой байлгаж байгаа нь олон жил хамтран ажиллаж байгаа түрээслэгчийн бизнесийн үйл ажиллагааг дэмжиж мөн түрээслэгчдийн тоог бууруулахгүй байх зорилготой ажиллаж байна.

Зарлага

Тайлант жилд 3165,0 сая төгрөгийн үйл ажиллагааны зардалтай ажилласан байна. Компаний зардлыг гол нэр төрлөөр нь авч үзье.

д/д	Зардлын төрөл	Дүн /сая/	Зардалд эзлэх хувь
1	2	3	4
2	Үндсэн цалин	807,2	25,50%
3	НДШ	89,5	2,83%
4	Ашиглалтын зардал	418,7	13,23%
5	Шуудан холбоо, бичиг хэрэг, үйлчилгээ	99,8	3,15%
6	Шатахуун	140,0	4,42%
7	Хөдөлмөр хамгаалал зардал	15,2	0,48%
8	Урсгал засвар бусад үйлчилгээний зардал	72,2	2,28%
9	Сэлбэг	221,6	7,00%
10	Хангамж, барилгын материал	275,1	8,69%
11	Хог тээвэрлэлт, тээврийн зардал	125,8	3,97%
12	Элэгдлийн зардал	136,1	4,30%
13	Түүхий эд материалын зардал	190,9	6,03%
14	Зар сурталчилгаа	15,8	0,50%
15	Албан томилолт	11,6	0,37%
16	ББӨртөг	205,7	6,50%
17	Бусад	286,7	9,06%
18	Татвар болон бусад зардал	29,4	0,93%
19	Зээлийн хүүгийн зардал	23,7	0,75%
	Үйл ажиллагааны нийт зардал	3165,0	100%

2022 онд гарсан нийт үйл ажиллагааны зардлыг 2021 онтой харьцуулахад 904,3 сая төгрөгөөр өссөн нь засгийн газраас ашиглалтын зардлыг чөлөөлсөн мөн нийт зардлын 24,0 % ийг эзэлж буй засвар үйлчилгээний материалын үнэ өссөнтэй холбоотой харагдаж бна. 2022 онд гарсан нийт үйл ажиллагааны зардлын 24,0 %ийг үйлчилгээний заалуудын гол зардал болох урсгал засварын зардал, 28,33 -ийг ажилчдын цалингийн зардал 13,2 % ийг ашиглалтын зардал эзэлж байна.

Ашиг

Тайлант жилд 416,8 сая төгрөгийн эргэлтийн хөрөнгөтэйгээр үндсэн үйл ажиллагаагаа явуулж 3418,2 сая төгрөгийн орлоготой 3165,0 сая төгрөгийн үйл ажиллагааны зардал гарч 169,3 сая төгрөгийн ашигтай ажилласан байна.

Дансны авлага

д/д	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл /сая/	Эцсийн үлдэгдэл /сая/
1	Байгууллага	247,5	256,6
2	Хувь хүн		
3	Ажилчид	14,9	39,8
4	Дүн	272,2	296,4

2022 оны эцсийн үлдэгдэл болж буй 296,4 сая төгрөгийн авлага нь тодорхой хугацаатай, байгууллага хувь хүн болон ажилчдын ахуй хэрэгцээнд зориулагдсан түр зээл хэлбэрээр байна.

Дансны өглөг

д/д	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл /сая/	Эцсийн үлдэгдэл /сая/
1	Байгууллага		
2	Хувь хүн	29,2	19,1
3	Ажилчид	10,2	20,0
4	Татварын өглөг	160,7	252,1
5	НДШ-ийн өглөг	11,4	
6	Ноогдол ашгийн өглөг	130,7	130,5
7	Банкны зээл	380,2	246,7
	Дүн	722,4	668,4

Нийт өр төлбөр 54,0 сая төгрөгөөр буурсан байна.

Ногдол ашиг

"Тээвэр Дархан" ХК 2008-2019 онуудад нийт **739,4** сая төгрөгийн ногдол ашиг хувьцаа эзэмшигчдэдээ хуваарилсан.

№	Он	Нэгж хувьцаанд ногдох ашиг (төг)	ДҮН /сая/
1	2008	500	76,4
2	2009	300	47,1
3	2010	300	48,3
4	2011	400	62,3
5	2012	400	63,5
6	2013	400	40,9
7	2014	500	81,6
8	2015	500	23,7
9	2016	500	87,7
10	2017	500	148,3
11	2018	500	0,5
12	2019	500	10,6
12	2019	500	48,5
	дүн		739,4

Ногдол ашгийн өглөг нь өөр газар оршин суудаг бидэнтэй харьцдаггүй хувьцаа эзэмшигчид байдаг бөгөөд Санхүүгийн Зохицуулах Хороо энэ мөнгийг Монголын Хөрөнгийн Биржид төвлөрүүлэх шаардлага тавьдаг боловч, зохих бичиг баримттайгаа ирвэл ногдол ашгийг нь өгөхөд бэлэн байна.

Дүгнэлт:

Санхүүгийн үйл ажиллагаандаа нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцсэн "ДАЯН СОФТ" программыг ашиглан ажиллаж байна. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн дагуу санхүүгийн хөндлөнгийн хяналтыг "ПИЙК ОМ Аудит" ХХК-тай гэрээ байгуулан, улирал бүрийн тайлан балансад дүгнэлт гаргуулан, зөвлөгөө авч ажилладаг бөгөөд өгсөн зөвлөмж дүгнэлтийг мөрдлөг болгон ажиллаж байна. "ПИЙК ОМ Аудит" ХХК мэргэжлийн зөвлөмжөөр сайн ханган ажиллаж байна.

Тайлант жилд НӨАТ-т 213,8 сая төгрөг, ХАОАТ-т 54,7 сая төгрөг ААНОАТ-т 25,3 сая төгрөг болон бусад татварын тооцоонд 29,3 сая төгрөг, НДШ-д 188,6 сая төгрөг нийт 511,7 сая төгрөгийг улсын төсөвт орууллаа.

Цаашид компаний орлогыг нэмэгдүүлж, хөрөнгийн ашиглалтыг сайжруулах компаний хувьцаа эзэмшигчдэд ноогдох ашгийг нэмэгдүүлэх зорилтыг тавьж ажиллах болно.

Анхаарал тавьсан та бүхэнд баярлалаа.

Ерөнхий ня-бо



Д.Бямбажаргал

“Тээвэр Дархан” ХК-ний төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүдийн товч тайлан

Тус компанийн хараат бус гишүүдийн хороо нь компаний тухай хуулинд заасан эрх үүргийнхээ хүрээнд компанийн 2022 оны санхүүгийн, жилийн үйл ажиллагааны үр дүнгийн талаар товч танилцуулъя.

“Тээвэр Дархан” компани нь 2022 онд үндсэн үзүүлэлт болох нийт хөрөнгийн дүн 3617,9 сая төгрөг, үүнээс эргэлтийн хөрөнгө 416,8 сая, эргэлтийн бус хөрөнгө 3201,1 сая төгрөг тус тус байна.

2022 онд нийт борлуулалтын орлого 3418,2 сая төгрөг байгаа нь 2021 онтой харьцуулахад борлуулалтын орлого 1344,3 сая төгрөгөөр өссөн дүнтэй байна.

Тайлант жилдээ 3418,2 сая төгрөгийн орлоготой 3165,0 сая төгрөгийн зардал гарч 169,3 сая төгрөгийн ашигтай ажилласан байна. Компанийн тайлан баланс эдийн засгийн үзүүлэлтүүдтэй танилцсаны үндсэнд компаний хараат бус гишүүдийн зүгээс дараахь дүгнэлтийг хийж байна.

1. Компаний санхүүгийн тайлан балансад хөндлөнгийн аудит хяналт шалгалтын “ПИЙК ОМ” аудит, ХК-тай гэрээ байгуулан зөвлөмж авч санхүүгийн тайлан балансаа мэргэжлийн түвшинд гаргаж байгааг тус хороо сайшаан тэмдэглэж байна.
2. Орлого зарлагын тоо хэмжээ болон бусад үзүүлэлтүүдийг харахад эдийн засгийн үзүүлэлт урьд оныхоос өссөн дүнтэй байгааг сайн гэж дүгнэж байна.
3. Урьд онуудад ковид-19 цар тахалын нөлөө компаний үйл ажиллагаа, эдийн засгийн үзүүлэлтүүдэд хүндрэл учруулж байсан боловч тус компани нь үйлчлүүлэгчиддээ түрээсийн төлбөрт хөнгөлөлт үзүүлж, ажлын байр орон тоог зохих хэмжээнд хадгалах нөхцөлийг бүрдүүлж байсан нь бага ч гэсэн үр дүнгээ өгч байсаныг аудитын хороо 2021 оны тайлан, дүгнэлтэндээ цохон тэмдэглэж байсан билээ.
4. Компанийн мөнгөн эх үүсвэрийг бүрдүүлдэг зах, худалдааны төвүүдийн түрээслэгч хамт олныхоо санаа бодлыг сонсож, ажлын байр, ая тухтай ажиллах, нөхцөл бололцоог анхааралдаа авч улам сайн ажиллах шаардлагатай байна.
5. Цаашдаа 2022 оноос компаний үйл ажиллагаа тогтворжих, ажил үйлчилгээ явуулах нөхцөл бүрдэж байгааг харгалзан, оновчтой зөв шийдлээр хөрөнгө босгох, компаний ашиг орлогыг нэмэглүүлж, хөрөнгийн ашиглалтыг сайжруулахад анхаарал тавин ажиллах шаардлагатай байна.

Анхаарал тавьсанд баярлалаа.

“Тээвэр Дархан” компаний Төлөөлөн Удирдах Зөвлөлийн
аудитын хороо

